

**СҮХБААТАР АЙМГИЙН ДАРЬГАНГА СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

12 дугаар сарын мэдээлэл

2021.12.23.

Нэг. ТӨРИЙН УДИРДЛАГЫН ЧИГЛЭЛЭЭР.

1. Сумын ИргэдийнТөлөөлөгчдийн Хурлын ээлжит 6 дугаар хуралдаан 2021.12.17 ны өдөр хуралдаж дараахь асуудлыг хэлэлцэв. Үүнд:

1/. 2021 оны газар зохион байгуулалын тайлан, 2022 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөө хэлэлцэн батлав.

2/. Сумын Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хэлэлцэн “Хангалттай” үнэлгээ өгсөн.

3/. ИТХ-ын болон ЗДТГ, “Дарьганга тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-ын бүтэц орон тоог батлав.

4/. 2020 оны төсвийн гүйцэтгэл, 2022 оны төсөв батлах тухай

5/. ИТХ-ын дэргэдэх хороодын бүрэлдэхүүнийг өөрчлөх тухай хэлэлцэн шийдвэрлэв.

6/. Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн болон татварын орлогын тухай тус тус хэлэлцсэнээс Төсвийн талаар хэлэлцэх асуудлыг хойшлуулан 2021.12.23 нд дахин хэлэлцэв.

“Өмч хамгаалах байнгын зөвлөл” хуралдаж, үндсэн хөрөнгө данснаас хасах, актлах асуудлыг хэлэлцэн хөрөнгийг актлах тухай холбогдох баримт бичгийг аймгийн Өмчийн газарт хүргүүллээ.

“ОНХС-ийн үйл ажиллагааг зохицуулах тухай хууль тогтоомж, журмын өөрчлөлт, “Тогтвортой амьжиргаа-3” төслөөс боловсруулсан сургалтын модуль, 2021 оны жилийн гүйцэтгэлийн үнэлгээг танилцуулах үүрэг бүхий ажлын хэсэг 3 хүний бүрэлдэхүүнтэй суманд ажиллав.

2. Хоёр. Хөдөө аж ахуйн болон төв суурингийн өвөлжилтийн хүрээнд:

2021 оны жилийн эцсийн хүн ам өрх, малын тооллогын ажлыг зохион байгуулж, нийт 242009 мал тоологдож, үүнээс тэмээ 162, адуу 27655, үхэр 25302, хонь 121467, ямаа 67482 толгой тоологдож, таван төрөл дээрээ мал өслөө.

2021 оны 12 дугаар сарын байдлаар төв суурингийн өвөлжилт хэвийн, нэгдсэн халаалтын зууханд 240 тн нүүрсний нөөцтэй байна.

-Аймгийн Мал эмнэлгийн газрын ажлын хэсэг 3 хүний бүрэлдэхүүнтэй 2021.12.23 нд ирж, мал эмнэлгийн чиглэлээрх үйл ажиллагааны гүйцэтгэл, стандартыг тусгай удирдамжийн хүрээнд үзэж танилцав.

Гурав. БОЛОВСРОЛ, СОЁЛ УРЛАГИЙН ЧИГЛЭЛЭЭР

1/.Аймаг сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд “Иргэдийн наадам-2021” үйл ажиллагаанд сумаас 25 тамирчин оролцож 2 төрөлд алт, хүрэл медалийн болзол хангаж, багийн дүнгээр II байрт шалгарсан.

2/. Соёл урлаг, спортын үйл ажиллагааны “ХАРИУЦЛАГЫН ГЭРЭЭ” байгуулан танхимын 50 хувийн дүүргэлттэйгээр зарим үйл ажиллагааг зохион байгуулж байгаагаас “БЦГХЗахиргаа, Дуучин Б. Отгонбаяр, нартай гэрээ байгуулсан. 2021.12.29 нд нийтээр амрах баярын өдрийг тохиолдуулан “Бөхийн барилдаан”-ыг явуулна.

Дөрөв. ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР

Коронавируст халдвараас сэргийлэх дархлаажуулалтын үзүүлэлт

1-р тун 2371/2264 буюу 94%

2-р тун 2371/2224 буюу 93%

3-р тун 2371/1003 буюу 50,9 %-тай байна.

ЕБС -ын эмч , Эрүүл мэндийн багш , ЭМТ-ын НЭМА нар хамтран дэлхийн ДОХ-ын эсрэг өдөрт зориулан дунд ангийн 10-12-р ангийн 47 сурагчдад сургалт зохион байгуулж, ханиад томуугаас урьдчилан сэргийлэх талаар танилцуулан "АХА" тэмцээнийг зохион байгууллаа.

БШУС-ын 2021 оны 01 дүгээр сарын 21-ны өдрийн А/20 дугаар тушаалыг үндэслэн “Үдийн хоол”-ны хяналтын комиссыг 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж үдийн хоолонд хяналт тавин ажиллаж байна

Бага ангийн 3-5-р ангийн сурагчдын дунд үлгэр болон зохиолыг уншин судлуулж, “Миний уншсан зохиолын баатар” гар зургийн уралдаанд нийт 158 суралцагч бүтээлээ ирүүлсэн.

2021 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр болсон Монгол Улсын үндсэн хуулийн 30 жилийн ойг тохиолдуулан улсын УИХ-ын даргын ивээл дор зохион байгуулагддаг шатар сонирхогчдын 2021 оны Дарьганга сумын аварга шалгаруулах тэмцээнийг амжилттай зохион байгууллаа.

Тав. Байгаль орчны чиглэлээр:

- Сумын Засаг даргын 2021 оны 04 дүгээр сарын 30ний А/57 дугаар захирамжаар “Хашаагаа тохижуулъя” уралдааны шалгуур үзүүлэлтүүдийг хангаж шалгарсан айл өрхийн шагналыг гардууллаа.

- Хог хаягдлыг ангилан ялгах зорилгоор нийт 2,500,000 төгрөгийн санхүүжилтийг Байгаль хамгаалах сангаас шийдвэрлэн 3 цэгт ангилан ялгах хогийн сав байршууллаа.

-Байгаль хамгаалах сангаас 1500000 (нэг сая таван зуун мянган) төгрөгийн санхүүжилтээр гадна камер 2-ыг шинээр байршууллаа.

МЭДЭЭ НЭГТГЭСЭН
МЭРГЭЖИЛТЭН Д. МӨНХЗУЛ

ХЯНАСАН
СУМЫН ЗАСАГ ДАРГА Д. БОЛДБААТАР